

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/91/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Сайншанд хот	Утас: 70522734 Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.COM
2019 он	Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
	Утас:70523020 Цахим хаяг: Lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайшандаг сум,
3 дугаар баг, Орхон нутгийн захиралын III байр,
Утас: (705) 2-27-34

**УЛААНБАДРАХ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ХИШИГБАЯР ТАНАА**

2019.02.04 № 1-6/259
таныг _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбадрах сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбадрах сумын ЗДТГ нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГазар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ЗДТГ-ын дарга М.Хишигбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.02.20-наас 2018.03.04-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018.03.04-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт албан тоотоор ирүүлээгүй байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Улаанбадрах сумын ЗДТГ нь “Төр эдийн засаг, нийгмийн бодлогын үйл ажиллагаа” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн үйл ажиллагааг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Улаанбадрах сумын ЗДТГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход өндөр гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг тогтоов.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны Нийт зардал 3,594.23 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3,594.23 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар	0	0.00	

шилжүүлсэн

5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	0	0.00

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2 Зардлын данстай холбоотой

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас шилжүүлсэн 555.1 мянган төгрөгийн материалыг орлого авалгүйгээр шууд зардалд бичсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14.4-т “нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал”, мөн санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх гэсэн аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар шууд зардалд бичсэн 555.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

2.8.3 Зардлын данстай холбоотой

Цалингийн дансны ангиллыг буруу сонгон бичилт хийснээс үр дүнгийн тайланд цалингийн зардал 930.9 мянган төгрөгөөр илүү тусгагдсан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн зөв байх гэсэн аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар ажил гүйлгээг санхүүгийн тайланд залруулав.

2.8.4 Балансын данстай холбоотой

Тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгийн 34.5 сая төгрөгийн хөрөнгийг актлахдаа тухайн хөрөнгө худалдсаны 8.9 сая төгрөгийн гарзыг бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.40-д “Дт-мөнгө Дт-хуримтлагдсан элэгдэл Дт-Үндсэн хөрөнгө худалдсаны гарз, Кт-Үндсэн хөрөнгө” гэсэн дансны бичилттэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар хөрөнгө акталсны 8,979.4 мянган төгрөгийн гарзыг санхүүгийн тайланд тусган залруулав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 241,666.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардалд 241,560.0 мянган төгрөгийг зарцуулсанаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 185,916.1 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 55,643.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 438.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Улаанбадрах сумын ЗДТГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна. Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ЗДТГ 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,914,080.60	45,289,807.55
33	АВЛАГА	962,900.00	117,618.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	743,400.00	40,498.00
335	Бусад авлага	219,500.00	77,120.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	219,500.00	77,120.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,951,180.60	45,172,189.55
351	Түүхий эд материал	849,504.00	849,504.00
35110	Тусгай зориулалттай материал	849,504.00	849,504.00
354	Хангамжийн материал	37,816,476.60	42,037,485.55
35410	Бичиг хэргийн материал	1,817,320.00	1,850,195.00
35420	Аж ахуйн материал	25,622,880.60	29,275,068.75
35440	Түлш, шатах тослох материал	10,376,276.00	10,912,221.80
35600	Мал амьтад	2,285,200.00	2,285,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,321,470,329.44	1,730,727,328.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,321,470,329.44	1,730,727,328.41
392	Биет хөрөнгө	1,321,120,329.44	1,649,100,328.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	844,192,800.00	886,775,167.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162,294,173.45	-4,670,312.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	200,933,800.00	196,481,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-119,672,862.03	-139,539,460.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110,601,351.98	102,887,362.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,243,292.53	-77,174,655.96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,022,862.63	26,261,652.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,263,692.26	-21,060,648.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	795,865,220.00	896,262,921.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-270,021,684.90	-217,122,996.66
393	Биет бус хөрөнгө	350,000.00	81,627,000.00
39301	Програм хангамж	2,644,000.00	2,644,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,294,000.00	-2,294,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	81,277,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,363,384,410.04	1,776,017,135.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,561,800.00	898,889.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,561,800.00	898,889.00
413	Өглөг	1,561,800.00	898,889.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,561,800.00	898,889.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,361,822,610.04	1,775,118,246.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,361,822,610.04	1,775,118,246.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	614,713,671.73	695,990,671.73
51101	Өмч: - төрийн	614,713,671.73	695,990,671.73
512	Хуримтлагдсан үр дүн	535,056,391.77	313,547,485.37
51210	Өмнөх үеийн үр дүн	535,056,391.77	535,797,570.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-222,250,085.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	212,052,546.54	765,580,089.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,363,384,410.04	1,776,017,135.96

3.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	477,294,693.42	409,978,177.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	206,843,231.42	150,073,557.00
120	Нийтлэг татварын бус орлого	206,843,231.42	150,073,557.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	206,843,231.42	150,073,557.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,479,550.00	5,332,250.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	201,363,681.42	144,741,307.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	270,451,462.00	259,904,620.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,140,862.00	23,238,020.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,137,280.00	23,167,262.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,582.00	70,758.15
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	256,310,600.00	236,666,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,310,600.00	236,666,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	391,598,577.21	361,456,354.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,598,577.21	361,456,354.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,640,849.21	357,137,534.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	185,916,108.00	174,323,453.00
210101	Үндсэн цалин	185,916,108.00	166,823,453.00
210104	Урамшуулал	00.00	7,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,268,861.00	22,262,200.00
210201	Тэтгэврийн даатгал	13,913,401.00	14,406,511.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,774,180.00	1,952,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,579,114.00	1,615,586.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363,438.00	410,168.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,638,728.00	3,877,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,393,670.00	12,944,367.00
210301	Гэрэл, цахилгаан	1,030,570.00	1,422,767.00
210302	Түлш, халаалт	14,283,100.00	11,341,600.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,935,876.42	24,648,077.20
210401	Бичиг хэрэг	3,114,613.00	4,271,008.00
210402	Тээвэр, шатахуун	9,123,776.42	13,917,538.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,014,100.00	1,796,761.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	283,000.00	842,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,309,970.00	3,820,270.00
210408	Бараа материал акталсны зардал	90,417.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	1,200,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,720,968.00	337,900.00
210604	Урсгал засвар	8,720,968.00	337,900.00
2107	Томилолт, зочны зардал	5,943,800.00	2,738,100.00
210702	Дотоод албан томилолт	5,943,800.00	2,738,100.00

Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,551,391.00	16,824,315.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,577,800.00	15,760,691.00
210803	Даатгалын үйлчилгээ	483,591.00	257,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	435,000.00	483,810.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	267,814.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,910,174.79	101,859,122.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,420,400.00	4,420,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,489,774.79	97,439,122.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,957,728.00	4,318,820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,500,000.00	3,880,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,500,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	438,820.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	438,820.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	457,728.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,728.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	85,696,116.21	48,521,822.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	760,436.48	270,771,907.62
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	760,436.48	8,979,387.43
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	261,792,520.19
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-760,436.48	-270,771,907.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	84,935,679.73	-222,250,085.16

3.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	126,855,380.00	276,998,912.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,570,800.00	5,332,250.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,570,800.00	5,332,250.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,570,800.00	5,332,250.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,570,800.00	5,332,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	124,284,580.00	271,666,662.15
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,135,980.00	35,000,062.15
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,204,980.00	23,167,262.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,931,000.00	11,832,800.15
131106	Төсвийн урамшуулал	00.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,148,600.00	236,666,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,148,600.00	236,666,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	109,404,271.00	276,998,912.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,404,271.00	276,998,912.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	108,404,271.00	272,680,092.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	85,923,617.00	174,323,453.00
210101	Үндсэн цалин	85,923,617.00	166,823,453.00
210104	Урамшуулал	00.00	7,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,441,660.00	22,262,200.00
210201	Тэтгэврийн даатгал	6,052,093.00	14,406,511.00
210202	Тэтгэмжийн даатгал	768,052.00	1,952,501.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	774,212.00	1,615,586.00
210204	Ажилгүйдлийн даатгал	167,540.00	410,168.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,679,763.00	3,877,434.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	548,893.00	13,135,767.00
210301	Гэрэл, цахилгаан	533,893.00	1,455,767.00
210302	Түлш, халаалт	00.00	11,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	15,000.00	180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,436,380.00	20,965,028.00
210401	Бичиг хэрэг	352,820.00	3,401,883.00
210402	Тээвэр, шатахуун	2,799,720.00	13,974,634.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	143,840.00	1,906,761.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	140,000.00	1,281,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	400,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,400,000.00
210502	Хоол, хүнс	00.00	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	290,930.00	2,161,680.00
210604	Урсгал засвар	290,930.00	2,161,680.00
2107	Томилолт, зочны зардал	2,821,800.00	2,738,100.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,821,800.00	2,738,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,262,691.00	18,441,064.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,720,100.00	17,377,440.00
210803	Даатгалын үйлчилгээ	146,050.00	257,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,541.00	483,810.00

Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210807	Газрын төлбөр	00.00	267,814.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,678,300.00	17,252,800.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,678,300.00	17,252,800.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	4,318,820.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	3,880,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,880,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	438,820.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	438,820.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,451,109.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,451,109.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,451,109.00	00.00

3.2 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	614,713,671.73	212,052,546.54	535,056,391.77	1,361,822,610.04
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	614,713,671.73	212,052,546.54	535,056,391.77	1,361,822,610.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	741,178.76	741,178.76
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	614,713,671.73	212,052,546.54	535,797,570.53	1,362,563,788.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	553,527,543.32	00.00	553,527,543.32
D08	Тайлант үеийн үр дүн	81,277,000.00	00.00	-222,250,085.16	-140,973,085.16
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	695,990,671.73	765,580,089.86	313,547,485.37	1,775,118,246.96

3.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	241,666,600.00	241,560,030.00	438,820.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,666,600.00	241,560,030.00	438,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,666,600.00	241,560,030.00	438,820.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,320,400.00	174,283,453.00	36,947.00
210101	Үндсэн цалин	166,820,400.00	166,783,453.00	36,947.00
210104	Урамшуулал	7,500,000.00	7,500,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,262,200.00	22,262,200.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	14,841,407.00	14,841,407.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,855,198.00	1,855,198.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,484,159.00	1,484,159.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	371,039.00	371,039.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,710,397.00	3,710,397.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,146,600.00	13,135,767.00	10,833.00
210301	Гэрэл, цахилгаан	1,466,600.00	1,455,767.00	10,833.00
210302	Түлш, халаалт	11,500,000.00	11,500,000.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	180,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,685,600.00	17,655,366.00	30,234.00
210401	Бичиг хэрэг	2,617,500.00	2,612,883.00	4,617.00
210402	Тээвэр, шатахуун	11,464,100.00	11,463,972.00	128.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,904,000.00	1,896,761.00	7,239.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,300,000.00	1,281,750.00	18,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	400,000.00	0.00
2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,408,000.00	1,407,520.00	480.00
210604	Урсгал засвар	1,408,000.00	1,407,520.00	480.00
2107	Томилолт, зочны зардал	2,738,100.00	2,738,100.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,738,100.00	2,738,100.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,905,700.00	9,877,624.00	28,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,814,000.00	8,814,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	264,000.00	257,000.00	7,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	485,000.00	483,810.00	1,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00
210807	Газрын төлбөр	287,700.00	267,814.00	19,886.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,666,600.00	241,666,600.00	0.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	241,666,600.00	241,666,600.00	0.00
132001	Орон нутгийн төсвөөс	241,666,600.00	241,666,600.00	0.00

3.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,407,280.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	20,407,280.00
4	Бараа, үйлчилгээний зардал	19,407,280.00
22	Хангамж, бараа материалын зардал	266,180.00
24	Тээвэр (шатахуун)	266,180.00
39	Томилолт, зочны зардал	958,100.00
41	Дотоод албан томилолт	958,100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,500,000.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,500,000.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	16,683,000.00
54	Бараа үйлчилгээний бусад зардал	16,683,000.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00
70	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,483,780.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,483,780.00
124	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,137,280.00
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,346,500.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00
134	Удирдах ажилтан	7.00
135	Гүйцэтгэх ажилтан	10.00
136	Үйлчлэх ажилтан	8.00